БАТЛАВ
УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА Л.ЧУЛУУН
2016... он 07..... сар 01....... өдөр

Зөвшөөрсөн:
Дагат түмэг ...ХХК-ны ..................
Захирал ........... Б.
2016... он 07....... сар 01......... өдөр

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

**№**

Чингис хот

2016он 07 сар 01 өдөр

Монгол Улсын Иргэний хуулийн 343-358дугаар зүйлийг удирдлага болгон энэхүү гэрээг нэг талаас захиалагч ............................................ ХХК-г төлөөлж ........................................../цаашид захиалагч гэнэ/, нөгөө талаас Хэнтий аймгийн УЦУОШАлбаны БОШЛабораторийн эрхлэгч инженер Б.Ганганбайгал /цаашид гүйцэтгэгч гэнэ/ нар харилцан тохиролцож байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Гүйцэтгэгч байгууллага нь захиалагч байгууллагын хүсэлтээр дараахи орчноос сорьц авч шинжилгээг хийнэ. Үүнд:

- Агаар
- Хөрс
- Ус
- Цацраг
- Ургамлын нөмрөг

1.2. Гүйцэтгэгч байгууллага нь дараахи үзүүлэлтээр шинжилгээг хийж дурьдсан хугацаанд үр дүнг хүргүүлнэ.

<u>Үзүүлэлтүүд</u>

А. Агаар

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Хүхэрлэг хий ($SO_2$) | 13000 |
| 2 | Азотындавхар исэл ($NO_2$) | 12000 |
| Нийт | | 25000 |

Б. Хөрс

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Анхан шатны боловсруулалт | 5000 |
| 2 | Эрдэс фосфор ($PO_4$) | 2000 |
| 3 | Сульфатын ион ($SO_4$) | 2000 |
| 4 | Аммоний азот ($NH_4$) | 4000 |
| 5 | Нитратын азот ($NO_3$) | 5000 |
| 6 | Урвалын орчин /pH/ | 2500 |
| 7 | Чийг | 2500 |
| 8 | Ялзмаг | 5000 |

WWW.ILTODGEREE.MN
ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | |
|---|---|
| Нийт | 28000 |

Б. Ус

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Усан орчин /pH/ | 780 |
| 2 | Цахилгаан дамжуулах чанар /Ec/ | 760 |
| 3 | Жинлэгдсэн бодис | 3800 |
| 4 | Ууссан хүчилтөрөгч | 2800 |
| 5 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | 14000 |
| 6 | Перманганатын исэлдэх чанар | 4000 |
| 7 | Хатуулаг | 1100 |
| 8 | Кальцийн ион | 960 |
| 9 | Магнийн ион | 620 |
| 10 | Натри+Калийн ион | 610 |
| 11 | Гидрокарбонатын ион | 1740 |
| 12 | Хлорын ион | 1440 |
| 13 | Сульфатын ион | 1570 |
| 14 | Эрдэсжилт | 820 |
| 15 | Аммонийн азот | 2100 |
| 16 | Нитритийн азот | 2300 |
| 17 | Нитратын азот | 3600 |
| 18 | Эрдэс фосфор | 1600 |
| 19 | Төмөр | 1500 |
| 20 | Фтор | 1800 |
| Нийт | | 47900 |

Г. Цацраг

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Агаар | 10000 |
| 2 | Хөрс | 10000 |

Д. Ургамалын нөмрөг

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Бэлчээрийн ургамлын голлох зүйлийн бүрэлдэхүүн | 25000 |
| 2 | Бэлчээрийн ургамлын бүрхэцийн хэмжээ | 10000 |
| 3 | Бэлчээрийн ургамалын өндөр, ургац | 25000 |
| 4 | Бэлчээрийн талхлагдалтын үнэлгээ | 15000 |
| Нийт | | 90000 |

1.3. Шинжилгээ хийх газар

| № | Шинжилгээний сорьц авах байршил /Хаяг/ | Шинжилгээний сорьцийн тоо | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ус | Хөрс | Агаар | Ургамал | Цацраг | |
| | | | | | | Хөрс | Агаар |
| 1 | "Дацан трейд" | 6 | 6 | 6 | - | - | - |

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ХХК | | | | | | |
| Нийт тоо | | 6 | 6 | 6 | - | - | - |
| Үнэ /төгрөг/ | Нэгж | 47900 | 28000 | 25000 | 90000 | - | - |
| | Бүгд | 287400 | 168000 | 150000 | - | - | - |

Дүн- 605400 төгрөг

1.4. Гэрээний хугацаа 2016.12.31

- Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа 2 сар
- Ажил эхлэх хугацаа 9 сарын 01
- Ажил дуусах хугацаа 11 сарын 01

## 2. Захиалагчийн эрх үүрэг

2.1. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардагдах нөхцөлийг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Шинжилгээний дээж авах объект нь УЦУОША-ны БОШЛ-аас 5 км-с хол зайд байрладаг бол унаагаар хангах.
- Хөдөө орон нутагт ажиллах бол ажиллах хугацааны томилолт, унаа, буудлын зардлыг бүрэнхариуцна.

2.2. Гүйцэтгэгч хүссэн тохиолдолд шинжилгээ хийлгэх объектийн талаархи мэдээлэл өгөх

2.3. Гүйцэтгэгчийн ажил үйлчилгээний явцад хяналт тавих

2.4. Ажил гүйцэтгэсний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд саадгүй төлнө.

## 3. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.

3.2. Сорьц авч, шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн ажилтнаар биечлэн гүйцэтгүүлнэ.

3.3. Сорьц авах объектэд ажлын нөхцөлийг бүрдүүлэх талаар шаардлага тавих хэрэгтэй.

3.4. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

3.4. Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалж захиалагчид учирсан хохирлыг гүйцэтгэгч хариуцахгүй.

## 4. Ажлын хөлс, төлбөр тооцоо

4.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нэгж объетоос дээж авч шинжилгээ хийсний нийт төлбөр болох 605400 төгрөг /үсгээр/ зургаан зуун таван мянга дөрвөн зуун төгрөг байна.

Захиалагч байгууллага гэрээ байгуулсаны дараа ажил эхлэхийн өмнө нийт үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний урьдчилгаа төлбөрийг бэлэн / бэлэн бус хэлбэрээр төлсөн байна.

4.2 Захиалагч үлдэгдэл төлбөрөө нэхэмжлэлийн дагуу 30 хоног буюу ажлын 22 хоногт багтаан бүрэн хийсэн тохиолдолд гүйцэтгэгч шинжилгээний хариуг хүлээлгэн өгнө.

4.3 Гүйцэтгэгч ажилтанд нэг өдрийн томилолтын зардал болох 25000 төгрөгийг захиалагч тал олгоно.Жич: Байр, унааны зардал ороогүй болно. / Хэрэв ажлыг тодорхой хэсгээр үе шаттай гүйцэтгэхээр тохиролцсон бол тухайн хэсгийн ажлын үр дүнгээр хөлсийг хэсэгчлэн төлнө.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

## 5. Талуудын хүлээх хариуцлага

5.1 Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацааг хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.

5.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

5.3 Захиалагч төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.

5.4 Гэрээг 2 хувь үйлдэх ба талууд 1 хувийг хадгална.

## 6 Бусад заалт

6.1 Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.3 Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл /шүүх арбитр/-аар шийдвэрлүүлнэ.

## 7.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

7.1 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.2 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

## 7. Нэмэлт нөхцөл

______________________________________________________________________
______________________________________________________________________
______________________________________________________________________
____________________

Гэрээ байгуулсан

Захиалагч : .................... **ХХК**-ийг төлөөлж

Хаяг:

Утас:

Гүйцэтгэгч: **Хэнтий аймаг**
**УЦУОША**-ыг төлөөлж
Б. Ганганбайгал
БОШЛ-ийн эрхлэгч
/................................/
Хаяг: Хэрлэн сум 2 баг
Тэмүүжингийн гудамж Н-13
Утас: 98892200 гар
93028611 УЦУОША

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN